

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2020 оны 8 сарын 20 өдөр

№ 1017

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү гэрээг нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар /цаашид Захиалагч гэх/, нөгөө талаас “Ариг-Эрдэнэ” ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/, харилцан зөвшилцөн Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.1, 476.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.8 дахь заалтыг үндэслэн харилцан тохиролцож дор дурдсан нөхцөлөөр энэхүү “Үйлчилгээ үзүүлэх гэрээ” (цаашид гэрээ гэх)-г байгуулав.
- 1.2. Хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулна.
- 1.3. Энэхүү гэрээгээр коронавируст халдвар (COVID-19)-ын цартахлын голомттой улс орноос ирсэн эмнэлзүйн шинж тэмдэггүй иргэнийг түр тусгаарлан эмчийн хяналтанд тусгаарлах, ажиглах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.4. Тусгаарлах, ажиглах байранд халдварын эрсдэлийг тооцон иргэнийг эмчийн хяналтанд 21 хоног тусгаарлана.

Хоёр. Талуудын эрх, үүрэг

2.1. Захиалагч дараах эрх, үүргийг хүлээнэ.

- 2.1.1. Захиалагч тал тусгаарлах, ажиглах байранд тусгаарлах иргэнийг зохих журмын дагуу аюулгүй байдлыг ханган хүргэнэ.
- 2.1.2. Тусгаарлах, ажиглах байранд тусгаарлах хүний тоог урьдчилан төлөвлөж, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдад халдварын сэргийлэлт хяналттай холбоотой зохих мэдээллийг өгч, сургалт зохион байгуулна.
- 2.1.3. Урьдчилан бэлтгэлийг хангуулах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын гаргасан хүсэлтэд үндэслэн шаардлагатай тохиолдолд урьдчилгаа төлбөрийг шилжүүлж болно. (нийт төлбөрийн 70 хувь хүртэл)
- 2.1.4. Тусгаарлах, ажиглах байрыг Цагдаагийн байгууллагын хяналтанд байлгаж аюулгүй байдлыг хангана.
- 2.1.5. Тусгаарлагдсан иргэдийн эрүүл мэндэд хяналт тавих эмч томилон ажиллуулна.
- 2.1.6. Гэрээний үүргийн хугацаа дуусгавар болсоны дараа төлбөрийн үлдэгдлийн зохих хувийг гүйцэтгэлээр тооцож шилжүүлнэ.
- 2.1.7. Тусгаарлах, ажиглах байрны өрөөний эд хөрөнгө, тавилга хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг захиалагч тал хариуцахгүй.

Year	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Q1	1.2	1.5	1.8	2.1	2.4	2.7	3.0	3.3	3.6	3.9	4.2	4.5	4.8	5.1
Q2	1.5	1.8	2.1	2.4	2.7	3.0	3.3	3.6	3.9	4.2	4.5	4.8	5.1	5.4
Q3	1.8	2.1	2.4	2.7	3.0	3.3	3.6	3.9	4.2	4.5	4.8	5.1	5.4	5.7
Q4	2.1	2.4	2.7	3.0	3.3	3.6	3.9	4.2	4.5	4.8	5.1	5.4	5.7	6.0
Annual	1.6	1.9	2.2	2.5	2.8	3.1	3.4	3.7	4.0	4.3	4.6	4.9	5.2	5.5

2.1.8. Захиалагч тал нь Гүйцэтгэгч талаас үйлчилгээний болон хоолны чанар стандартыг хангуулах зорилгоор шаардлага тавьж болно.

2.2. Гүйцэтгэгч тал дараах эрх, үүргийг хүлээнэ.

2.2.1. 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Монгол Улсын Шадар сайдын “Үнэ тогтоох тухай” 23 дугаар тушаалд заасан төлбөрийг тусгаарлагдсан иргэдийн тоогоор нэхэмжлэх эрхтэй.

2.2.2. Тусгаарлах, ажиглах байранд ажиллах үйлчилгээний ажилчдыг 21 хоног байршуулан ажиллуулна.

2.2.3. ХӨСҮТ болон бусад эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн шалтгаанаар шилжсэн иргэний төлбөрийг байрласан хоногоор тооцон тухайн байгууллагад шилжүүлнэ.

2.2.4. Шуурхай штаб, мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийг чанд мөрдөж ажиллана.

2.2.5. Чанар стандарт, аюулгүй байдлын шаардлага хангасан, амт чанар, тэжээллэг хоолоор үйлчилнэ.

2.2.6. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний аюулгүй байдлыг хангана.

2.2.7. Хүнсний үйлчилгээний ажилтан, ажиллагсдыг ажиглалтанд байгаа хүмүүстэй харьцахгүй байхаар зохион байгуулна.

2.2.8. Үйлчилгээ, хоолны чанартай холбоотой гарсан гомдлыг тухай бүр нь дотооддоо шийдвэрлэн захиалагч талд мэдэгдэж ажиллана.

2.2.10. Захиалагчаас шаардсан мэдээллийг тухай бүрт нь үнэн зөв гаргаж хүргүүлнэ.

2.2.11. Гүйцэтгэгч талууд тэгш эрхтэйгээр үүрэг, хариуцлага хүлээнэ.

Гурав. Давагдашгүй хүчин зүйл

3.1. Гэрээнд оролцогч талуудаас үл хамаарах байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ талаар 24 цагийн дотор харилцан мэдэгдэх үүрэгтэй бөгөөд түүний улмаас ямар нэгэн хохирол учирсан тохиолдолд талууд хариуцлага үл хүлээнэ.

Дөрөв. Хариуцлага

4.1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд гэрээг дуусгавар болсонд тооцно.



4.1.2. Хэрэв энэ гэрээнд заасан болон түүнтэй холбогдох асуудлаар маргаан гарвал талууд харилцан зөвшилцлийн замаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүх байгууллагаар шийдвэрлүүлнэ

4.1.3. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга дарснаар гэрээ хүчин төгөлдөр болсонд тооцож, тал тус бүр нэг хувийг хадгална.

Тав. Төлбөр, төлбөр төлөх нөхцөл

- 5.1 Гэрээний нийт төлбөрийг тооцоо нийлсэний үндсэн дээр тухай бүр тооцох болно.
5.2 Энэхүү гэрээний төлбөрийг тусгаарлах байранд иргэдийг байршуулсанаас хойш ажлын 10 хоногийн дотор талууд тооцоо нийлж банкны тоот дансанд төлнө.
5.3 Талууд тусгаарлах байрны төлбөрийг зориулалтын дагуу ашиглана.

Гэрээ байгуулсан:

<p>Захиалагчийг төлөөлж</p> <p>Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа</p> <p> Г.Бат-Эрдэнэ (гарын үсэг)</p> <p>Хаяг: Партизан 6, Сүхбаатар Дүүрэг 5-р хороо, Улаанбаатар Төв, Монгол Улс</p> <p>Холбоо барих утас: 51-262489,</p> <p>Э-шуудан: obeg_sankhuu@yahoo.com ХАЯГ: ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР</p>	<p>Гүйцэтгэгчийг төлөөлж</p> <p>"Ариг-Эрдэнэ" компаний менежер Үүриймаа овогтой Бямбадорж (гарын үсэг)</p> <p>ХАЯГ: ХУД 6-р хороо, 5 дугаар гудамж, 88 тоот УТАС: 99071009</p> <p>Гүйцэтгэгчийг төлөөлж</p> <p>Захирал Батаев овогтой Хонгорзул  (гарын үсэг)</p> <p>ХАЯГ: БЗД, 26-р хороо, Нарлаг өргөө, Хүннү гудамж 723-р байр 47 тоот УТАС: 99111163</p>
--	--

Vertical line of text or artifacts in the center of the page.

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000164546

2006.03.10

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011056010

/ Хувцйн хэргийн дугаар /

2543192

/ Регистрийн дугаар /

Ариг-Эрдэнэ

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

1

/ дугаар /

1997.06.20

/ он, сар, өдөр /

4610

/ код /

Гадаад худалдаа

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

5510

5610

4799

4774

6810

7911

0150

4520

Зочид буудал *U*

Ресторан, баар, караоке

Худалдааны зуулчлал

Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ

Үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, худалдаа, зуулчлал, түрээс

Аялал жуулчлал

Газар тариалан

Авто машины угаалга

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1



/ гишүүдийн тоо /

180,300.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол, 20-р хороо, энхтайваны өргөн чөлөө, 296/3, Утас1: 70180663, Утас2: 70180661,
Факс:


/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /




Гэрчилгээ дахин олгосон 2018 он 6 сар 29 өдөр

1117141800

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлийн бүртгэл



Д/А	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Огноо
1	Батвее овоотой Хонгорзул-а Захирал-р томилсны бүртгэв.	2007.04.09
2	Дахин гэрчилгээ олгов.	2018.06.29



2019-04-08 өдөр Бүртгэлийн № ...575...
 Нийслэлийн Баянзүрх дүүргийн
 тойргийн нотариатч Д.Цэцэгчимэг би
 энэ хуулбарын үнэн зөвийг гэрчлэв.
 Үйлчилгээний хөлсөнд ...25000... төгрөг хураав
 Нотариатч

